



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Говь-Алтай аймгийн Дарив сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2022 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын хураангуй тайлан

Аудитын код: ГАА-2023/01/НА-СТА-ТТЗ

Цахим хуудас: www.audit.mn

Алтай хот

2023 он

Дарга, Тэргүүлэх аудитор: Х.Түвшинбаяр

Утас: 70483413 Цахим хаяг: tuvshinbayarkh@audit.gov.mn

Аудитын менежер: Д.Эрдэнэчимэг

Утас: 70484055 Цахим хаяг: erdenechimegd@audit.gov.mn

Аудитор

Э.Сүнжидмаа

Утас: 80048599

Цахим хаяг: Sunjidmaae@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

Хоёр. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

	/мянган төгрөгөөр/	
Үзүүлэлт	2021.12.31	2022.12.31
Санхүүгийн байдлын тайлан		
Эргэлтийн хөрөнгийн дүн	885.7	679.1
Эргэлтийн бус хөрөнгийн дүн	6,234.4	1,217.4
Нийт хөрөнгийн дүн	7,120.1	1,896.6
Нийт өр төлбөрийн дүн	127.9	120.9
Цэвэр хөрөнгө/өмчийн дүн	6,992.2	1,775.6
Өр төлбөр, цэвэр хөрөнгө/өмчийн дүн	7,120.1	1,896.6
Санхүүгийн үр дүнгийн тайлан		
Үйл ажиллагааны орлогын дүн	3,584.7	1,164.8
Үйл ажиллагааны зардлын дүн	3,492.8	855.1
Үйл ажиллагааны үр дүн	91.9	309.8
Үйл ажиллагааны бус үр дүн	125.2	5,489.4
Үйл ажиллагааны нийт үр дүн	-33.2	-5,179.6
Цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан		
Дахин илэрхийлсэн үлдэгдэл	7,025.5	6,992.1
Тайлант оны үр дүн	-33.3	-5179.6
Эцсийн үлдэгдэл	6,992.1	-1,775.6
Мөнгөн гүйлгээний тайлан		
Үйл ажиллагааны мөнгөн орлогын дүн	3,486.5	1,394.9
Үйл ажиллагааны мөнгөн зарлагын дүн	3,174.9	1,094.6
Үйл ажиллагааны ЦМГ	311.6	300.3
Хөрөнгө оруулалтын ЦМГ	231.8	337.9
Санхүүгийн ажиллагааны ЦМГ	66.3	-29.9
Нийт цэвэр мөнгөн гүйлгээ	146.1	-67.5
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	192.3	338.4
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	338.4	270.9
Төсвийн гүйцэтгэлийн тайлан		
Нийт зарлага ба цэвэр зээлийн дүн		
Урсгал зардал	1158.1	1058.1
Хөрөнгийн зардал		
Зардлыг санхүүжүүлэх эх үүсвэр		
Орон нутгаас төсвөөс санхүүжих	905.1	826.9
Орон нутгийн хөгжлийн сангаас санхүүжих	145.6	145.6
Өөрийн орлогоос санхүүжих	107.3	54.5



ГОВЬ-АЛТАЙ АЙМГИЙН ДАРИВ
СУМЫН ЗАСАГ М.МЭНДБАЯР
ТАНАА

**ГОВЬ-АЛТАЙ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

1402, Хөгжил хороолол, Жинст баг,
Есөнбулаг сум, Говь-Алтай аймаг, 82099
Утас: 70-48-34-13. Факс: (976) 70-48-34-13,
Цахим шуудан: govialtai@audit.gov.mn
Цахим хаяг: www.audit.mn

2023.03.24 № 134
танай _____ -ны № _____ -т

Хязгаарлалттай дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.2-д заасны дагуу Говь-Алтай аймгийн Засаг даргын тамгын газрын 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Дүгнэлтийн үндэслэл хэсэгт дурдсан алдаа, зөрчлийн үр нөлөөг эс тооцвол дагуу Говь-Алтай аймгийн Дарив сумын төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторовын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторовын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Аудитаар шилэн дансны мэдээллийг дутуу мэдээлсэн, орон нутгийн орлогыг 65.8 сая төгрөгөөр тасарсан, 2023 оны 03 дугаар сард хувьчлагдсан Дарив сумын “Эрчим хүч” ААТҮГ-ын 2022 оны 12 сарын 31-нээр тасалбар болсон санхүүгийн тайлан аудит хамрагдаагүй нь Төсвийн тухай хууль, Шилэн дансны тухай хууль, АДБОУС 1250, иж бүрэн, тасалбар болголт, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Аудитын онцолсон хэсэг

Монгол Улсын Засгийн газрын 2022 оны 03 дугаар сарын 30-ны өдрийн 131 дүгээр тогтоолоор “Сургуулийн өмнөх болон бага, дунд боловсролын, мэргэжлийн боловсролын, техникийн боловсролын сургалтын байгууллагын төсвийн төвлөрүүлэн захирагч нь Боловсролын ерөнхий газрын дарга” гэсэн агуулгатай заалт оруулсан байна.

0702000310

Аудитын гол асуудал

Тус байгууллага нь тайлант онд 43 арга хэмжээг хэрэгжүүлэхээр гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусгаж, биелэлтийг 88.0 хувийн биелэлттэй гэж дүгнэсэн байна

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ
АУДИТОР

Х.ТҮВШИНБАЯР



Гурав. Аудитын илрүүлэлт

Аудитаар нийт 43.0 сая төгрөгийн алдаа¹ илэрснийг аудитын явцад залруулсан. Үүнд:

Нягтлан бодох бүртгэлтэй холбоотой:

- ✓ Санхүүгийн байдлын тайланд бараа материалыг 0.7 сая төгрөгөөр, борлуулах зорилгоор эзэмшиж буй бусад эргэлтийн хөрөнгийг 96.9 сая төгрөгөөр зөрүүтэй илэрхийлсэн
- ✓ Үр дүнгийн тайланд орлогыг 1.9 сая төгрөгөөр, зардлыг 0.7 сая төгрөгөөр зөрүүтэй илэрхийлсэн
- ✓ Мөнгөн гүйлгээний тайланд орлогыг 6.0 сая төгрөгөөр зөрүүтэй илэрхийлсэн нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.10-т "Аудитын байгууллагаас зөвлөмж болгосон бүртгэлийн алдааны залруулгыг мэргэжлийн түвшинд хянан, удирдлагад танилцуулах, зөвшөөрсөн тохиолдолд тухайн санхүүгийн жил, улирлын тайланд залруулга хийх, зөвшөөрөөгүй тохиолдолд аудиторт үндэслэл бүхий тайлбар хүргүүлэх" заалтыг зөрчсөн байна.

Аудитаар нийт зөрчил илрээгүй.²

6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

Байгууллагын нэр	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж	
							Залруулсан		Залруулаагүй			
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Алтай сумын Төсвийн төвлөрүүлэн захирагч	1	43.0					1	43.0				
Алтай сумын ЗДТГ	1	31.8					1	31.8				
Алтай сумын ИТХ	0	-							-			
Алтай сумын ОНХС	1	205.2					1	205.2				
Алтай сумын Хоршоо хөгжүүлэх сан	0	-										
Алтай сумын БХНС сан	0	-										
Дүн	3	280.0	0	-	0	-	3	280.0	0	0	0	0

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/сая

төгрөгөөр/

Байгууллагын нэр	Нийт зөрчил	Үүнээс				
		Төлбөрийн акт	Албан шаардлага	Зөвлөмж	Хариуцлага тооцуулах албан шаардлага	Хууль, хяналтын байгууллагад шилжүүл

¹ Тайлагнасан санхүүгийн тайлангийн үзүүлэлт, тайлагнасан байвал зохих үзүүлэлтийн хоорондын зөрүү. Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/.

² Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

Тус байгууллага нь нэгдсэн халаалтын системд холбогдсон боловч тоолуур ашиглаагүй	1	-	-	-	1	-	-	-
Авто тээврийн хэрэгсэлд тод өнгийн дэвсгэр бүхий улсын дугаар хийгээгүй	1	-	-	-	-	-	1	-
Дүн	2	-	-	-	1	-	1	-
Нийт дүн	3	-	-	-	2	-	1	-

Тав. Төсвийн захирагчийн ангиллаар аудитад хамрагдсан байдал ба санал дүгнэлтийн талаарх мэдээллийн нэгтгэл

№	Төсвийн захирагчийн ангилал	Байгууллага, нэгжийн тоо				Санал дүгнэлтийн хэлбэр			
		Аудитад хамрагдах	Үүнээс: Аудит хийсэн хэлбэр			Өөрчлөлтгүй	Хязгаарлалттай	Сөрөг	Дүгнэлт өгөхөөс татгалзсан
			Санал дүгнэлт гаргасан	Түүвэрт хамруулсан	Аудит хийгээгүй				
A	1	2	3	4	5	7	8	9	10
1	Дарив сумын ТТЗ	1	1	-	-	1	-	-	-
2	Дарив сумын ЗДТГ	1	1				1		
3	Дарив сумын ИТХ	1		1					
4	Дарив сумын ОНХС	1		1					
5	Дарив сумын Хоршоо хөгжүүлэх сан	1		1					
6	Дарив сумын БХНСС	1		1					
	НИЙТ	6	2	4	-	1	1	-	-